

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа:

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар

Техник импорт ХК  
УБГД:9010001041  
ҮЦК: 441  
Утасны дугаар: (+976) 70001830

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Бизнесийн үйл ажиллагааны салбар

Гадаад худалдаа

Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг

144,675,5

Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр

Бэлтгэсэн:  
Санхүү, бизнес хариуцсан захирал  
С.Дашдулам  
ТУЗ-ын н.б.д О.Бүжинлхам  
Хянасан:  
Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэг

1.

Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын үзүүлэлт

Тайланг хавсаргав.

Орлогын тайлан

Тайланг хавсаргав.

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайланг хавсаргав.

Мөнгөн гүйлгээний тайлан

Тайланг хавсаргав.

2.

Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт

	<p>Техник импорт ХК нь санхүүгийн үйл ажиллагаагаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) болон Монгол улсад мөрдөгдөж байгаа НББ-ийн хууль тогтоомж, журам, зааврын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бүртгэл тооцоог явуулдаг.</p> <p>Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо 2024 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар компанийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж Техник импорт ХК-ийн 2024 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах бүх өр төлбөр, орлого, зардал, хөрөнгө МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлж тусгагдсан байна гэж дүгнэсэн.</p>	
3.	<p><i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i></p>	
3. 1.	<p><i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Цэвэр хүүний маржин (NIM) 1,5%</li> <li>2. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 0,008%</li> <li>3. Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 0,037%</li> </ol>
3. 2.	<p><i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i></p>	<ol style="list-style-type: none"> <li>4. Нийт активын өөрчлөлт 1,03%</li> <li>5. Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө/ 0,23%</li> <li>6. Өр төлбөр /Нийт хөрөнгө/ 0,77%</li> <li>7. Хөрвөх чадвартай хөрөнгө 1,3%</li> </ol>
3. 3.	<p><i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i></p>	<p>Компанийн үйл ажиллагаанд инфляцын түвшин, гадаад валютын ханш, зах зээл дээр борлуулагдаж байгаа цемент, мотоцикл, битумын болон бусад бараа бүтээгдэхүүний үнэ чухал нөлөө үзүүлдэг.</p> <p>Тайлант хугацаанд импортын болон дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ тогтмол өссөн үзүүлэлттэй, 2023 онд үүссэн бэлэн мөнгөний хомсдол арилаагүй, харилцагч байгууллагуудын худалдан авах чадвар буурсан, улс орны хэмжээнд сонгууль болохтой холбогдуулан томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт хойшлогдож зам, барилгын ажлын явц удааширсан, өмнөх жилүүдтэй харьцуулахад оройтож эхэлсэн нь компаниас бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, бараа бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үндсэн шалтгаан болсон.</p> <p>Компанийн удирдлагаас компанийн үйл</p>

		ажиллагааг хэвийн, тогтвортой явуулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлж ажилласан. Тайлант хугацаанд компаниас борлуулах бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төрөлд ямар нэгэн өөрчлөлт ороогүй болно.
3. 4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
		Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор компанийн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлаараа Худалдаа хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 15 тэрбум төгрөгийн зээл авах асуудлыг хэлэлцсэн. Тус хурлаас 15 тэрбум төгрөгийг 12 сарын хугацаатай, жилийн 16%-ийн хүүтэй авч ашиглах, банкны зээлийн барьцаанд зохих журмын дагуу үл хөдлөх хөрөнгө, ирээдүйн орлогоос орж ирэх мөнгөн хөрөнгийг барьцаалуулах эрхийг Гүйцэтгэх удирдлагад олгохоор шийдвэрлэсэн. СЗХ-ноос баталсан “Үнэт цаасны журам”-д заасны дагуу уг журамд заасан хугацаанд зээлийн талаар хэлэлцсэн компанийн ТУЗ-ын шийдвэр, тогтоолыг холбогдох нотлох баримтын хамт СЗХ, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилласан.
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>	
		Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлээгүй тул татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.
6.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	

Техник импорт ХК нь 1958 онд байгуулагдсан, Монгол Улсын импортын ууган компани бөгөөд үйл ажиллагааны чиглэлийн дагуу гадаад, дотоодын олон байгууллагатай хамтран ажилладаг, зам, барилга, тээвэр зууч, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний худалдаа, хөдөө аж ахуйн салбарт өөрийн хувь нэмрээ оруулан ажилладаг, зах зээлд байр сууриа эзэлсэн, үнэ цэнэтэй харилцагчидтай, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг хүлээсэн, мэргэжлийн ур чадвартай, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, 2 дугаар ангилалд багтдаг нээлттэй хувьцаат компани билээ.

#### **Компанийн удирдлагын бүтэц, үйл ажиллагаа**

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Төлөөлөн удирдах зөвлөл
3. Гүйцэтгэх удирдлага

#### **Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл жил бүр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулдаг.

Тайлант хугацаанд компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр холбогдох хууль, журмын дагуу амжилттай зохион байгуулж явуулсан.

ХЭХ-ын тооллогын комисс Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зориулж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-иас гаргасан “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-ны дагуу хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, баталгаажуулсан.

Компаниас гаргасан нийт энгийн хувьцааны тоо 1,446,755 ширхэг бөгөөд “Хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-гаар 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн бүртгэлийн өдрөөр 461 хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн.

Компанийн нийт энгийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийн хувьцааг дараахь Хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны төрөл	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшиж буй хувь
1.	Д.Ганбат	Энгийн	475 161	32,84%
2.	Д.Ганцэцэг	Энгийн	455 736	31,5%
3.	Г.Содбилэг	Энгийн	480 300	33,2%
4.	Нийт		1 411 197	97,54%

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь оролцсоноос гадна ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүд биечлэн оролцож хууль, журамд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажилласан.

ХЭХ-ын Тооллогын комиссоос компанийн “Дүрэм”-д заасны дагуу нийт хувьцаа эзэмшигчдийн 60%-иас дээш буюу хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь оролцсоныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсон.

ХЭХ-ын дэгийн дагуу 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
2. 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
3. 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
4. 2023 оны компанийн ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, 2024 оны ТУЗ-ын төсөв

## 5. 2024 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд компанийн Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Д.Ганцэцэг

1. 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ын өгсөн дүгнэлт
2. 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
3. 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

ТУЗ-ын нарийн бичгийн дарга О. Бүжинлхам

1. 2022 оны ногдол ашгийн тайлан
2. 2023 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, 2024 оны ТУЗ-ын төсөв

ТУЗ-ын гишүүн Г.Уран-Өлзий

1. 2024 оны ТУЗ-ын гишүүнд нэр дэвшигчдийг сонгох асуудлын талаар тус тус танилцуулж холбогдох хууль, журамд заасан мэдээлэл өгөх, хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, тодруулга хийх үүргээ биелүүлж ажилласан.

ТУЗ-ын гишүүдийн 2023 оны ажлын тайланг дүгнэж 2024 оны ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудлаар ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хуралдаж компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу 2023 оны ТУЗ-ын гишүүдийн ажлын тайланг үндэслэн 2024 оны ТУЗ-ын хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг, ТУЗ-ын ердийн гишүүнээр Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж.Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг дахин сонгох санал гаргаж ХЭХ-д нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн.

Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хурлын хэлэлцэх асуудлын дагуу ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан дүгнэлтийг хэлэлцэж компанийн засаглалын сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй, Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасан шаардлагуудыг бүрэн хангасан ТУЗ-ын хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг, ТУЗ-ын ердийн гишүүнээр Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж.Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг 2024 оны ТУЗ-ын гишүүнээр сонгож баталсан.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороог байгуулж гишүүдийг томилсон.

ХЭХ-ын Тооллогын комисс Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргуулахтай холбогдуулан ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудлыг кумулятив аргаар, бусад хэлэлцсэн асуудлыг саналын хуудсаар санал авч шийдвэрлэсэн.

Хуралд оролцсон нийт Хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцсэн асуудлуудыг бүрэн дэмжиж хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

### 2. Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм.

Компанийн ТУЗ-ын гишүүдийг холбогдох хууль, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас, ТУЗ-ын даргыг нийт гишүүдийн олонхийн саналаар сонгож баталдаг.

2024 оны ХЭХ-аас 9 нэр дэвшигчийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгож томилсон ба эдгээрийн 3 нь хараат бус гишүүнээр, 6 нь ердийн гишүүнээр сонгогдсон. ТУЗ-ын гишүүдийг хүйсээр нь ангилвал 5 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй гишүүн байна.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулсан бөгөөд Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, “ТУЗ-ын үйл

ажиллагааны журам”-д заасны дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд:

1. Ногдол ашиг хуваарилах тухай /2024.02.14 №01/
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай /2024.02.26 №02/
3. Банкнаас зээл авах эрх олгох тухай /2024.03.05 №03/
4. Зөвшөөрөл олгох тухай /2024.03.27 №04/
5. Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай /2024.03.19 №05/
6. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээ /2024.04.18 №06/
7. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох тухай /2024/

ТУЗ-ын нийт хуралд 9 гишүүн оролцож хурлаар хэлэлцсэн асуудлыг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Гүйцэтгэх захиралтай “Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-г байгуулан тус гэрээний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

### **3. Гүйцэтгэх удирдлага**

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг компанийн Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулж ажилладаг.

Компанийн Гүйцэтгэх захирлаар Дашдондог овогтой Ганцэцэг ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн удирдлагаас компанийн хэмжээнд 2024 оныг компанийн үйлчилгээний чанарыг сайжруулах, ажилтнаа бататгах жил” болгох зорилго тавьж энэ ажлын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажилласан. Үүнд:

1. Үйлчлүүлэгч байгууллага, иргэдийн тоог нэмэгдүүлж, харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх,
2. ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны дүрэм, журмуудыг мөрдлөг болгон хэвшүүлж ажиллахад нийт ажилтнуудын идэвхи чармайлыг дээшлүүлэх, бүтээлч чиг хандлагад сургах,
3. Өндөр мэргэжил, мэргэшил бүхий үнэнч шударга хүний нөөцөөр хангагдах,

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан шийдвэр, тогтоол, компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг доголдолгүй, үр ашигтай байдлыг хангах чиглэлээр дараахь ажлуудыг удирдан зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Үүнд:

1. 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилж олгох тухай ХЭХ-ын шийдвэр, тогтоолын дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тай “ҮЦТХТ ХХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ” байгуулж гэрээний дагуу Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ногдол ашгийн мөнгийг шилжүүлсэн.
2. 2024 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудтай харилцах хүрээнд албан бичиг солилцох, биечлэн уулзах хэлбэрээр хамтран ажиллаж тэдний хүсэлт, шаардлагад нийцүүлэн шаардлагатай бараа, материалыг заасан хугацаанд нь нийлүүлж ажилласан.
3. Компанийн хэмжээнд ISO 9001 чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэнд хяналт тавьж сайжруулах арга хэмжээ авч уг тогтолцоог чанаржуулах, үр дүнг хангаж ажиллах чиглэлээр хариуцсан албадын дарга нарт хугацаатай үүрэг, даалгавар өгч үр дүн, хэрэгжилтийн талаар байнга тайлан авч зөвлөмж өгч хэрэгжүүлэхэд удирдлагаар ханган ажилласан.

4. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Гранд мед” эмнэлэгтэй “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Техник импорт” ХК болон түүний охин компаниудын 200 гаруй ажиллагсдыг 71,770,000 /Далан нэгэн сая долоон зуун далан мянга/ төгрөгийн төлбөртэй эмнэлгийн багц шинжилгээнд бүрэн хамруулсан.

5. Компанийн хэмжээнд галын аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор оффисын барилгын галын усны шугам хоолойг стандартын дагуу сэргээн засварлаж хэвийн горимд оруулсны зэрэгцээ галын дүгнэлтийн ээлжит үзлэгт орох ажлыг зохион байгуулж явуулсан. Энэхүү ажлын хүрээнд Баянгол дүүргийн “Онцгой байдлын газар”-аас зохион байгуулж явуулсан “Гамшиг ослын нэгдсэн сургалт”-нд компанийн болон охин компаниудын нийт удирдлагуудыг ажилтнуудын хамт хамруулж оролцуулсан ба сургалтаар гамшиг ослын үед хэрхэн эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, аврах ажиллагаа үзүүлэх болон галын аюулгүй ажиллагааны талаарх үзүүлэн сургалттай танилцаж, эмнэлгийн тусламж, аврах ажиллагааны чадваруудаас суралцсан.

6. Компанийн ажилтнуудын мэргэжил, ур чадварын судалгааг гаргаж, түүнд тулгуурлан хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын гүйцэтгэлийг сайжруулж, чанаржуулах зорилгоор сургалтын төлөвлөгөө батлах, сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулах, гэрээний дагуу холбогдох ажилтнуудыг сургалтанд хамруулсан.

7. Ажлын нөхцөл, онцлогтой нь уялдуулан компанийн ажилтнуудыг чанар, стандартын шаардлага хангасан өвөл, зуны ажлын хувцас, хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж явуулсан.

*Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

Тайлант хугацаанд Техник импорт ХК нь холбогдох хууль, журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр ирүүлсэн **“Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай”** 9/78 тоот албан бичиг, Монголын хөрөнгийн бирж ХК-иас 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн **“Хамтран ажиллах тухай”** 01/39 тоот албан бичгээр өгсөн зөвлөмж, авах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллан Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан хугацаанд тавигдах шаардлагуудыг хангуулж компанийн засаглалтай холбоотой дараахь хугацаат тайлан, мэдээг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж ажилласан. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн 2023 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр, тогтоол
2. Техник импорт ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоол,
3. Техник импорт ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, тогтоол, холбогдох баримт материалууд
4. Хороонд бүртгэлтэй аудитын компаниар баталгаажуулсан Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
5. Техник импорт ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
6. Техник импорт ХК-ийн 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан
7. Техник импорт ХК-ийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг

хүргүүлж ажилласнаас гадна Хорооноос 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн “Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” 3/712 тоот албан бичиг, МХБ ХК-ийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/139 тоот албан бичгийн дагуу компанийн удирдлагаас 2024 оны ХЭХ-аас баталсан 2023 оны нэгж хувьцаанд “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг үндэслэн ҮЦТХТ ХХК-тай “ҮЦТХТ ХХК-иар ногдол ашиг зуучлуулан тараалгах гэрээ”-г байгуулж гэрээний дагуу компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ногдол ашгийн мөнгийг шилжүүлсэн.

Дээрх албан бичгээр ирүүлсэн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангаж ногдол ашгийн тайлан мэдээг 2024 оны 05 дугаар сарын 01-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж ажилласан.

Мөн тайлант хугацаанд Хорооноос ирүүлсэн Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажилтын дагуу өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангаж холбогдох журам, тайлан, нотлох баримтуудыг Хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлсэн.


Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Ганцэцэг

Албан тушаал: “Техник импорт” ХК-ийн

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....



(Тамга/тэмдэг)

Овог, нэр: .....

Албан тушаал: “Лидер экаунт аудит” ХХК  
аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: О.Бүжинлхам

Албан тушаал: ТУЗ-ын н.б.д

Гарын үсэг: .....

2024.07.31.